



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2026/082/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум  
2026 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор: Ц.Алтантуул

Утас : 91195554

Цахим хаяг: [tuul9565@gmail.com](mailto:tuul9565@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	<a href="#">4</a>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<a href="#">5</a>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	<a href="#">6</a>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	<a href="#">7</a>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУ С	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар сум, Завхан аймаг 81090  
Утас/Факс: 7046-36-12  
Цахирм урууцагч: zavkhan@audit.gov.mn

Ауд 6.002.16 № 170

тантай \_\_\_\_\_ -ийг № \_\_\_\_\_ -т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ТӨВИЙН ДАРГА Ч.ЛХАГВАЖАВ-Т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Зоонозын өвчин судлалын төв нь тайлант онд улсын төсвөөс 674.7 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан хаагчид ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчил илэрсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 73.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 27.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\Албан бичиг\А4-2025.docx

8126054

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>190,264,204.25</u></b>	<b><u>155,837,358.46</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,341,500.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,341,500.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	186,922,704.25	155,837,358.46
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	167,145,114.25	135,751,078.46
35130	Эм боох материал	167,145,114.25	135,751,078.46
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,777,590.00	20,086,280.00
35410	Бичиг хэргийн материал	1,365,300.00	964,450.00
35420	Аж ахуйн материал	17,393,290.00	14,515,830.00
35440	Түлш, шатах тослох материал	1,019,000.00	4,606,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>709,560,106.25</u></b>	<b><u>605,868,910.19</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	709,560,106.25	605,868,910.19
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	674,290,106.25	570,598,910.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	224,057,642.00	224,057,642.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,628,052.58)	(28,703,533.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,618,000.00	92,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,413,833.23)	(72,429,166.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	496,170,005.86	493,419,817.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,623,068.29)	(147,080,576.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,252,905.73	8,464,611.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,143,493.24)	(1,891,534.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,523,300.00	2,761,650.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,523,300.00)	(399,999.96)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,270,000.00	35,270,000.00
39301	Програм хангамж	820,000.00	820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(820,000.00)	(820,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,270,000.00	35,270,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>899,824,310.50</u></b>	<b><u>761,706,268.65</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,884,482.00</u></b>	<b><u>4,924,383.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,884,482.00	4,924,383.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,884,482.00	4,924,383.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,884,482.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,932,360.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	992,023.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	992,023.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>895,939,828.50</u></b>	<b><u>756,781,885.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	895,939,828.50	756,781,885.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	283,361,967.00	283,361,967.00
51101	Өмч: - төрийн	283,361,967.00	283,361,967.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	587,272,834.29	448,329,582.44
51210	Өмнөх үеийн үр дүн	587,272,834.29	587,487,525.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(139,157,942.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,305,027.21	25,090,336.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>899,824,310.50</u></b>	<b><u>761,706,268.65</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,058,534,351.18</b>	<b>713,579,474.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>422,631,740.18</b>	<b>37,700,574.17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	422,631,740.18	37,700,574.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	422,631,740.18	37,700,574.17
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	422,631,740.18	37,700,574.17
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>635,902,611.00</b>	<b>675,878,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	607,939,000.00	674,721,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,939,000.00	674,721,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,963,611.00	1,157,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,963,611.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,157,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>716,136,643.10</b>	<b>851,083,221.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>716,136,643.10</b>	<b>851,083,221.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	715,538,204.10	827,621,944.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	486,387,926.00	508,859,739.00
210101	Үндсэн цалин	486,387,926.00	508,859,739.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,487,767.00	65,828,918.00
210201	Тэтгэврийн даатгал	62,487,767.00	40,001,518.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,074,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	8,065,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,537,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	10,149,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,228,071.00	23,245,313.54
210301	Гэрэл, цахилгаан	3,186,751.00	4,345,113.54
210302	Түлш, халаалт	17,123,480.00	17,951,560.00
210303	Цэвэр, бохир ус	917,840.00	948,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,373,445.00	20,942,880.00
210401	Бичиг хэрэг	1,259,550.00	1,204,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,449,800.00	7,279,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,398,090.00	1,748,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,100.00	280,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,040,905.00	10,431,040.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,318,763.79	84,010,144.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,318,763.79	84,010,144.69
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,485,500.00	1,880,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,500.00	-
210604	Урсгал засвар	4,365,000.00	1,880,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,011,500.00	8,484,800.00
210702	Дотоод албан томилолт	13,011,500.00	8,484,800.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,656,035.00	2,214,057.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	996,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	358,335.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,900.00	182,284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	345,000.00
210807	Газрын төлбөр	352,800.00	479,823.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,589,196.31	112,156,092.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,589,196.31	112,156,092.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	598,439.00	23,461,276.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	18,708,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,708,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	598,439.00	4,753,276.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	598,439.00	4,753,276.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>342,397,708.08</b>	<b>(137,503,747.25)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,654,195.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,654,195.60
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	-	(1,654,195.60)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>342,397,708.08</b>	<b>(139,157,942.85)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>635,902,611.00</b>	<b>675,878,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>635,902,611.00</b>	<b>675,878,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	607,939,000.00	674,721,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,939,000.00	674,721,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,963,611.00	1,157,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,963,611.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,157,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>629,402,611.00</b>	<b>675,878,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>629,402,611.00</b>	<b>675,878,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>628,804,172.00</b>	<b>652,417,623.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	485,844,944.00	505,518,239.00
210101	Үндсэн цалин	278,637,633.00	267,243,825.00
210102	Нэмэгдэл	146,754,724.00	177,666,145.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,881,309.00	21,412,900.00
210104	Урамшуулал	36,571,278.00	39,195,369.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,421,767.00	69,713,400.00
210201	Тэтгэврийн даатгал	40,088,767.00	43,886,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,482,500.00	5,074,800.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	8,082,000.00	8,065,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	803,600.00	2,537,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,964,900.00	10,149,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,228,071.00</b>	<b>19,312,953.54</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,186,751.00	4,345,113.54
210302	үлш, халаалт	17,123,480.00	14,019,200.00
210303	Цэвэр, бохир ус	917,840.00	948,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,356,760.00</b>	<b>16,772,440.00</b>
210401	Бичиг хэрэг	1,095,950.00	803,150.00
210402	Тээвэр, шатахуун	10,018,800.00	10,866,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,398,090.00	1,748,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,100.00	280,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,618,820.00	3,074,450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,345,845.00</b>	<b>25,034,627.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,060,845.00	23,660,627.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,285,000.00	1,374,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,939,250.00</b>	<b>6,359,130.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	574,250.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,479,130.00
210604	Урсгал засвар	4,365,000.00	1,880,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,011,500.00</b>	<b>8,484,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,011,500.00	8,484,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,656,035.00</b>	<b>1,222,034.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	483,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	358,335.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,900.00	182,284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	345,000.00
210807	Газрын төлбөр	352,800.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>598,439.00</b>	<b>23,461,276.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>18,708,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,708,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>598,439.00</b>	<b>4,753,276.46</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	598,439.00	4,753,276.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>
222001	Тоног төхөөрөмж	3,450,000.00	-
223001	Бусад хөрөнгө	3,050,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,500,000.00)</b>	<b>-</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,305,027.21	587,272,834.29	895,939,828.50
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,305,027.21	587,272,834.29	895,939,828.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	214,691.00	214,691.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	283,361,967.00	25,305,027.21	587,487,525.29	896,154,519.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(214,691.00)	-	(214,691.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(139,157,942.85)	(139,157,942.85)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,090,336.21	448,329,582.44	756,781,885.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31  
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	674,721,600.00	669,970,570.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	674,721,600.00	669,970,570.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,013,600.00	651,262,570.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,148,300.00	505,518,239.00
210101	Үндсэн цалин	267,886,700.00	267,243,825.00
210102	Нэмэгдэл	180,274,600.00	177,666,145.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,107,500.00	21,412,900.00
210104	Урамшуулал	33,879,500.00	39,195,369.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,574,700.00	69,713,400.00
210201	Тэтгэврийн даатгал	45,747,300.00	43,886,000.00

210202	Тэтгэмжийн даатгал	5,074,800.00	5,074,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,065,200.00	8,065,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,537,500.00	2,537,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,149,900.00	10,149,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол</b>	<b>19,089,400.00</b>	<b>19,089,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,470,900.00	4,121,560.00
210302	Түлш, халаалт	14,019,200.00	14,019,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,599,300.00	948,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,489,800.00</b>	<b>16,496,440.00</b>
210401	Бичиг хэрэг	1,133,400.00	803,150.00
210402	Тээвэр, шатахуун	11,595,400.00	10,866,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	1,748,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	822,800.00	280,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,496,200.00	2,798,450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,117,100.00</b>	<b>25,034,627.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,660,700.00	23,660,627.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,456,400.00	1,374,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,703,900.00</b>	<b>5,703,630.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,479,400.00	4,479,130.00
210604	Урсгал засвар	1,224,500.00	1,224,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,500,000.00</b>	<b>8,484,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	8,484,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,</b>	<b>1,390,400.00</b>	<b>1,222,034.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	483,800.00	483,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	146,500.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,800.00	182,284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	197,500.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	345,000.00	345,000.00
210807	Газрын төлбөр	23,800.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,708,000.00</b>	<b>18,708,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,708,000.00</b>	<b>18,708,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай	18,708,000.00	18,708,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>674,721,600.00</b>	<b>674,721,600.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>674,721,600.00</b>	<b>674,721,600.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	674,721,600.00	674,721,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>18</b>	<b>18</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	3	3
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18</b>	<b>18</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	11	11

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
--------	--	---	---

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,155,053.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,155,053.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,053.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,553.54
210301	Гэрэл, цахилгаан	223,553.54
2104	Хангамж, бараа материалын зардал	276,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	276,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	655,500.00
210604	Урсгал засвар	655,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,157,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,157,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,157,300.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн Зорилт:**

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, дүрмийг эрхэмлэн дээдэлж ажиллах;
2. Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн 2022-2025 оны стратегээс 2023 оны хэрэгжилтийг хангаж ажиллах;
3. Хүний нөөцийг бэхжүүлж боловсон хүчнийг сургах, чадавхижуулах;
4. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллах;
5. Зоонозын халдварт өвчний байгалийн голомтын хяналт шинжилгээ, хүн амын дундах тандал судалгаа хийж мэдээллийн санг баяжуулах
6. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын халдварт өвчнүүдийг оношлох, оношлогооны чадавхийг сайжруулан молекул биологийн шинжилгээг нэвтрүүлэх, /автолаборатори/
7. Хүн амын дунд зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, цахим мэдээ, мэдээллийг албан байгууллага, ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх;
8. Зоонозын халдварт өвчний байгалийн голомтыг хянах, тандах, голомт илрүүлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх
9. Салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллах

**Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн зорилго:** Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа нотолгоонд тулгуурлан оновчтой зохион байгуулах замаар эрсдэлийг бууруулах

Хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд байхгүй

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:**

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
11. Эрүүл мэндийн тухай хууль
12. НЭМ-ийн тусламж үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 138,118.04 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөгөөр/*

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	3,341.50	-	(3,341.50)
Бараа материал	186,922.70	155,837.36	(31,085.35)

Үндсэн хөрөнгө	709,560.11	605,868.91	(103,691.20)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>899,824.31</b>	<b>761,706.27</b>	<b>(138,118.04)</b>
Өр төлбөр	3,884.48	4,924.38	1,039.90
Засгийн газрын хувь оролцоо	895,939.83	756,781.89	(139,157.94)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>899,824.31</b>	<b>761,706.27</b>	<b>(138,118.04)</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 186,922.70 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 45,408.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 24,581.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 104,075.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 155,837.36 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,085.35 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 4,549.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 5,569.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 21,637.2 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж 605,868.91 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 112,156.1 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 130,363.67 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

#### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

##### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 675,878.9 мянган төгрөг, нийт зарлагыг 675,878.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

##### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацаанд Улсын төсвөөс 674,721.6 мянган төгрөг төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 669,970.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгө ө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих</b>					
<b>71602</b>	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>				
80302	Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон зардал	674,721.6	669,970.5	4,751.1	99,7 %
<b>НИЙТ</b>		<b>674,721.6</b>	<b>669,970.5</b>	<b>4,751.1</b>	<b>99,7 %</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн хувьд 1,115.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс 501.8 мянган төгрөгийг тогтмол зардалд, 655.5 мянган төгрөгийг урсгал засварын зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Түлш шатах тослох материал худалдан авах	11,594.4	10,866.5
<b>ДҮН</b>			<b>11,594.4</b>	<b>10,866.5</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 3.6 Ерөнхий чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн судалгааны үр дүн:

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 8 чиглэлээр судалгаа авч, үр дүнг тайланд тусгалаа.

**-Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгаа:** Тус байгууллага нь 2025 онд хоолны хөнгөлөлтөд 24,107.5 мянган төгрөгийг төсөвлөж 21,412.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Байгууллагын дотоод журманд заасны дагуу өдрийн тарифыг 5.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

**- Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:** Тус байгууллагад 2025 оны жилийн эцсийн байдлаар 820.0 мянган төгрөгийн өртөг бүхий 3 төрлийн программыг ашиглаж байна.

**- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд зарцуулсан зардлын судалгаа:** Зарцуулаагүй байна.

- Бусад 5 чиглэлийн судалгаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 367,782.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,516.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,137.55 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 851,083.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,766.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,574.6 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 33 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 420.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлж барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	420.0	1	420.0	100%
Нийт дүн	1	420.0	1	420.0	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 67,890.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 65,828.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,061.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**5.1 Залруулсан алдаа:** Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг мөнгөн гүйлгээний тайлан үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн 65,828.9 мянган төгрөгийн алдаа байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.2 Төлбөрийн акт:** Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг 20 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсаныг ур чадварын нэмэгдлээр тооцож олгосон 2,061.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

##### 5.3 Албан шаардлага хүргүүлээгүй

##### 5.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Нийт илрүүлсэн 2,061.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг мөнгөн гүйлгээний тайлан болон үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	65,828.9			1	65,828.9	1	65,828.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>65,828.9</b>			<b>1</b>	<b>65,828.9</b>	<b>1</b>	<b>65,828.9</b>				

/Мянаан төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


/Мянаан төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн				Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн
Дарга Мөнхцэцэг нь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг 20 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсаныг ур чадварын нэмэгдлээр тооцож олгосон байна..	1	2,061.6	1	2,061.6								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,061.6</b>	<b>1</b>	<b>2,061.6</b>								

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА



ATA6366 5096376 1977198008

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Ц.ОЮУНСУВД

Ц.АЛТАНТУУЛ



Огноо: 2026-02-25